**ОРХОН АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2025 оны 12 дугаар сарын 25

Орхон аймаг

| № | Арга хэмжээ | Хугацаа | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Санхүүжилт /сая.төг/ | Хүрэх үр дүн | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт 1. Судалгаа, мэдээ, тайлан гаргах** | | | | | | | |
| 1. | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээллийн сан бүрдүүлэх | Жилдээ | Аймгийн ЗДТГ БОНХОБ ТХ | БОГ, ГХБХБГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ | - | Мэдээллийн сантай болсон байна. | 2025 онд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлт ирүүлсэн "Эрдэнийн цавчир уул" ХХК-ийн хүсэлтийг хүлээн авч аймгийн Засаг даргын 2025 оны А/513 дугаартай захирамжаар тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилээр сунгасан. Оны өвөлжөө ХХК-д түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг Аймгийн Засаг даргын 2025 оны А/512 дугаартай захирамжаар 15 жилийн хугацаатай олгосон.<br>Мөн Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хүсэлтийг хүлээн авч сум болон аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн аймгийн Засаг даргын 2025 оны А/590 дугаартай захирамжаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгосон.<br>Ашигт малтмал газрын тосны газрын Кадастрын бүртгэлийн цахим системд https://cmcs.mrpam.gov.mn/cmcs-д 2025 онд Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 1, хайгуулын тусгай зөвшөөрөл сунгасан 1, шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон 1 аж ахуйн нэгжийн талбайн солбицлыг баталгаажуулсан.<br>Мөн Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан болон тусгай зөвшөөрлийн жилийн төлбөрөө төлсөн аж ахуй нэгжийн мэдээллийг оруулж жилийн сунгалтыг хийсэн. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зөвшөөрлийн хугацаа дууссан Абуз ХХК-ийн талбайг Ашигт малтмал газрын тосны газрын Кадастрын бүртгэлийн цахим системд чөлөөлсөн. 2025 онд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход улсын тэмдэгтийг хураамж 2250000 төгрөг, тусгай зөвшөөрлийн жилийн төлбөрт 1953744 төгрөгийг аймгийн ЗДТГ-ын нэгдсэн дансанд төвлөрүүлсэн.<br>2025 оны жилийн эцсийн байдлаар Орхон аймагт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 11, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 2, ашигт малтмалын хайгуулын тусгай 5, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 2 орд байна. Энэ нь нийт 17841,04 га буюу Орхон аймгийн нийт газар нутгийн 21.1 хувийг эзэлж байна.<br>Хэрэгжилт 100% |
| 2. | Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээ гаргах | Улирал, жилээр | Аймгийн ЗДТГ СТСХ | Татварын хэлтэс, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ | - | Иргэдэд ил тод мэдээлэх ажил сайжирсан байна. | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудаас орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, сумын ЗДТГ, төсөвт байгууллагад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг холбогдох маягтын дагуу Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн нь жил бүр гаргаж Erdenet.mn д байршуулж нийтэд мэдээлж, тайлагнан ажиллаж байна<br>Хэрэгжилт 100% |
| 3. | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖСайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу гүйцэтгүүлж, батлуулан хэрэгжилтийг хангуулж ажиллах | Жилдээ | БОГ | БОНХОБТХ, МХГ, ГХБХБГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ | - | Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл буурна. | "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, БОАЖСайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, "Эрдмин" ХХК, "Ачит-Ихт" ХХК, "Зэс-Эрдэнийн хувь" ХХК, "Гал-сэнтий" ХХК, "Очир төв" ХХК-иудын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэхэд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ 96,09%, "Ачит-Ихт" ХХК 92,%, "Эрдмин" ХХК 96%, "Зэс-Эрдэнийн хувь" ХХК 96,2%, "Гал-Сэнтий" ХХК 96,09%, "Очир төв" ХХК 95,64 хувьтай тус тус дүгнэгдлээ. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хэрэгжилт 100% |
| 4. | Уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа айл өрх, иргэд, мал сүрэгт аюултай хог хаягдал, агаарын бохирдол, бусад сөрөг нөлөөллөөс үүсэж буй хор хөнөөлийн талаарх мэдээ, судалгаа гаргах | Жилдээ | БОАЖГ, ЭМГ, Стандарт хэмжил зүйн хэлтэс | Аймгийн ЗДТГ, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд, "Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ, "Төр иргэн түншлэл" ТББ, иргэд | - | Судалгааны сан бий болсон байна. | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Баяжуулах үйлдвэрийн Хаягдлын аж ахуй болон нөлөөллийн бүсүүдийн агаарын 14 дээжид 6 үзүүлэлтээр 84, хүрээлэн буй орчны агаарын 8 дээжид 14 үзүүлэлтээр 112 хэмжилт шинжилгээг тус тус хийж агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулсан.<br>Хүрээлэн буй орчин болон цагаан тоосны хэмжилтийн үр дүнгээс харахад салхины дундаж хурд 3,1-6,9 м/с байх үед нийт тоосны агууламж Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй.<br>Эрдэнэт, Хангал, Орхон голуудын 2025 оны шинжилгээг гадаргын усны цэврийн зэргийн ангиллын нормоор ангилахад шим бохирдлын үзүүлэлтүүд нь I-V ангиллуудад хамаарагдаж байна.<br>-Гадаргын усны бохирдлын индексээр тооцоход Эрдэнэт, Хангал, Орхон голуудын ус нь усны чанарын зэрэг III ангилал буюу бага бохирдолтой ангилалд хамаарагдаж байна.<br>-Уурхайн үйл ажиллагаанаас тухайн бүс нутагт үзүүлж байгаа хуримтлагдах нөлөөллийг тогтоох зорилгоор ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулж Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамд хүргүүлсэн.<br>Хэрэгжилт 70% |
| **Зорилт 2. Тайлан мэдээг иргэдэд нээлттэй, ил тод мэдээлэх** | | | | | | | |
| 5. | Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурвалжилга, мэдээ явуулах | Жилдээ | Хэвлэл мэдээллийн байгууллагууд, "Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ, "Төр иргэн түншлэл" ТББ | Аймгийн ЗДТГ, БОГ | - | Мэдээлэл олон нийтэд хүрсэн байна. | Аймгийн СУАЖЗГ-т Зэс фестиваль арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн 10.0 сая төгрөгийг шилжүүлсэн. Мөн 2025 оны 09 дүгээр сарын 18,19-ний өдрүүдэд "ЗЭС ФЕСТИВАЛЬ" арга хэмжээний хүрээнд уул уурхайн үйлдвэрүүдтэй танилцах аяллын хүрээнд 2 өдөр 350 гаруй иргэд, сурагчдыг үйлдвэрүүдтэй танилцуулсан. ETV телевизтэй хамтран мэдээ бэлтгэн, үйлдвэрийн аялалд явсан иргэд сурагчдаас сэтгэгдэл авч олон нийтэд түгээсэн. Зэс утасны үйлдвэрийн талаар видео контент бэлтгэн Аймгийн Засаг даргын албаны Facebook-ийн page хуудас, erdenet.mn сайт болон mining.mn пэйж хуудсаар түгээсэн.<br>Хэрэгжилт 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн мэдээллийг https://erdenet.mn/ сайтад өөрчлөлт орсон тухай бүр байршуулах. | Жилдээ | Аймгийн ЗДТГ | Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн мэдээллийг https://erdenet.mn/ сайтад өөрчлөлт орсон тухай бүр байршуулах. | Жилдээ | Аймгийн ЗДТГ | Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн мэдээллийг https://erdenet.mn/ сайтад өөрчлөлт орсон тухай бүр нь байршуулж байна. https://erdenet.mn/medee/newscategory/106/134 Хэрэгжилт 100% |
| 7. | ereport.eitimongolia.mn сайтад тайлан мэдээллийг хугацаанд нь оруулах | 2025.04. 15-06.15 | Аймгийн ЗДТГ СТСХ | - | - | Тайлан мэдээг бүрэн оруулсан байна. | Тайлант хугацаанд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Отгонтэнгэр оргил ХХК, Зунрун ХХК, Очиртөв ХХК зэрэг 13 байгууллагын Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Газрын төлбөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, Ус ашигласны төлбөрийг цахим системээр илгээж баталгаажуулсан байна. Хэрэгжилт 100% |
| **Зорилт 3. Хамтын ажиллагаа, түншлэл хөгжүүлэх, оролцогч талуудын чадавх бэхжүүлэх** | | | | | | | |
| 8. | Орхон аймаг, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Ачит-Ихт" ХХК, "Эрдмин" ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээ, түүний хэрэгжилтийн тайланг нээлттэй тайлагнах | Жилдээ | Аймгийн ЗДТГ | Хэвлэл мэдээллийн байгууллагууд, "Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ, "Төр иргэн түншлэл" ТББ | - | Хамтран ажиллах гэрээнд иргэдийн зүгээс тавих хяналт, мэдээлэл сайжирч, холбогдох мэдээллээр хангагдана. | Аймгийн хэмжээнд уул уурхайн ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Ачит-Ихт" ХХК, "Эрдмин" ХХК-уудтай байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр 2025-2028 онд хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулж, 2025 онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай 3.0 тэрбум, "Эрдмин" ХХК-тай 105.0 сая, "Ачит-Ихт" ХХК-тай 155.0 сая, "Зэс эрдэнийн хувь" ХХК-тай 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хамтран ажиллах төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангаан ажиллаж, гэрээ, төлөвлөгөөг эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан (www.iltodgeree.mn)-д мэдээлж Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад албан бичгээр хүргүүлсэн. Мөн Аймгийн Засаг даргын албаны Facebook-ийн page хуудас, erdenet.mn сайт, орон нутгийн хэвлэл |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдээллийн байгууллагын Facebook page хуудас болон албан ёсны мэдээллийн сайтууд болон mining.mn пэйж хуудсаар сурталчлан ажиллалаа.<br>Дээрх компаниудтай хамтын ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны 1 дүгээр сард хамтын ажиллагааны хороогоор хэлэлцэн дүгнэж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд аймгийн Засаг даргын 01/118 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Хэрэгжилт 100% |
| 9. | Хуульд заасан мэдээллийг үнэн зөв гаргаж нийтэд мэдээлээгүй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, тэдний гэрээт туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжид зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх | Жилдээ | БОГ | Аймгийн ЗДТГ | - | Мэдээллийг үнэн зөв мэдээлсэн байна. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 14 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж илэрсэн зөрчилтэй нь холбогдуулан улсын ахлах байцаагчийн 6 албан шаардлагыг 38 заалттайгаар өгч 8 хуулийн этгээдийн үйл ажиллагааг зөрчил арилтал түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авч ажилласан.<br>Хэрэгжилт 90% |
| 10. | Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн төсөвт 2025 онд төлж байгаа татвар, төлбөр, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, сумын ЗДТГ, төсөвт байгууллагад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг холбогдох маягтын дагуу жил бүр гаргаж нийтэд мэдээлэх, журмын дагуу тайлагнах | 4-р улиралд | Аймгийн ЗДТГ СТСХ | Татварын хэлтэс, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд | - | Мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь мэдээлсэн байна. | 2001 оноос "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж байсан бол 2013-2018 онд Хамтын ажиллагааны хэлэлцээр, 2018 оноос хамтран ажиллах гэрээ байгуулан гэрээний хүрээнд жил бүр төлөвлөгөө батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хүрээнд байгаль орчин экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах, хүн амын эрүүл мэнд, боловсрол, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих, дэд бүтэц нийгмийн асуудлаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Ачит Ихт ХХК, Эрдмин ХХК, Зэс эрдэнийн хувь ХХК-иудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.<br>2017-2025 онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай 19.7 тэрбум төгрөг, 2018-2025 онд Ачит Ихт ХХК-тай 1.7 тэрбум, 2021-2025 онд Эрдмин ХХК-тай 426.2 сая, 2024-2025 онд Зэс эрдэнийн хувь ХХК-тай 250 сая төгрөгийн хамтын ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн.<br>Уул уурхайн үйлдвэрүүдийн хамтын ажиллагааны гэрээ, төлөвлөгөөний талаарх мэдээллийг аймгийн Засаг даргын албаны Facebook-ийн page хуудас, erdenet.mn сайт, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын Facebook page хуудас болон албан ёсны |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдээллийн сайтууд болон mining.mn пэйж хуудсаар 30 гаруй удаа сурталчлан ажиллалаа. Хэрэгжилт 100% |
| 11. | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, дэд зөвлөлийг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Жилдээ | Аймгийн ЗДТГ | БОГ | 15.0 сая ОНТХО | Үйл ажиллагааны хяналт сайжирна. | Аймгийн Байгаль хамгаалах арга хэмжээний зардалд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд ажлын албанъ үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 15.0 сая төгрөг батлуулсан. 2025 онд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Дэд зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх, ашигт малтмал болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор "Хууль тогтоомжийн хэрэгжилт нөхөн сэргээлтийн үр дүнг сайжруулах нь" сэдэвт сургалтыг 32 аж ахуйн нэгжийн 40 албан хаагч, ажилчдад зохион байгуулсан.<br>Хэрэгжилт 100% |
| 12. | Жил бүрийн ажлын төлөвлөгөө, тайланг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албанд хүргүүлэх | Жилдээ | Аймгийн ЗДТГ | ОҮИТБС-ын дэд зөвлөл | - | Төлөвлөгөө,тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна. | Аймгийн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлтийг хугацаанд нь гарган ОҮИТБС-ын ажлын албанд хүргүүлэн ажиллаж байна.<br>Хэрэгжилт 100% |
| 13. | ОҮИТБС-н тайлангийн талаарх мэдээллийг олон нийтийн сүлжээгээр орон нутгийн компаниуд, төрийн албан хаагчдад хүргэх | Жилдээ | Аймгийн ЗДТГ Мэдээллийн алба | ОҮИТБС-ын дэд зөвлөл | - | 18-р тайлангийн тухай танилцуулга шторкийг аймгийн вэб хуудаст байрлуулсан байна. | Засаг даргын Тамгын газрын уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албанаас зохион байгуулсан iltodgeree.mn-д гэрээ оруулах цахим сургалтад хамрагдсан.<br>ОҮИТБС-н тайлангийн талаарх мэдээллийг олон нийтийн сүлжээгээр орон нутгийн компаниуд, төрийн албан хаагчдад хүргэн ажиллаж байна.<br>Хэрэгжилт 70% |
| ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ | | | | | | | 94.6% |

ТАНИЛЦСАН: БҮС ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ж.БАТ-ӨЛЗИЙ

ТАЙЛАГНАСАН: БҮС ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН У.ЧИГЭСТЭЙ